



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/248

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Сургуулийн
бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт
оюутан элсүүлэх журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 8.1 дэх заалт, МУИС-ийн Дүрмийн 4.3.8.4 дэх заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Их Сургуулийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Оюутан элсүүлэх тушаал гарсантай холбогдуулан элсэлтийн бодлого, журам сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулахыг Сургалтын нэгдсэн газар (Л.Одонтуяа), Элсэлтийн алба (М.Эрдэнэчимэг), Мэдээллийн технологийн газар (А.Баатарбилэг), Дотоод хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтэс (П.Лхамсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.


3. Оюутан элсүүлэх ажлыг энэхүү журмын дагуу зохион байгуулах, үр дүнд нь хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал (Б.Очирхуяг), Мэдээллийн технологийн газар (А.Баатарбилэг), Шинжлэх ухааны сургуулийн захирал (Б.Баяртогтох), Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн захирал (Н.Баатарбилэг), Бизнесийн сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч (Ч.Энхбаяр), Хууль зүйн сургуулийн захирал (Ж.Эрдэнэбулган), Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн захирал (С.Баттулга), Завхан сургуулийн захирал (П.Оюунбилэг), Эрдэнэт сургуулийн захирал (Т.Энх-Амгалан) нарт үүрэг болгосугай.

4. Захирлын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/334 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Их Сургуулийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР



Захирлын 2018 оны 06 дугаар сарын 28-ны
өдрийн 248 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ОРОЙ, ЭЧНЭЭ ХӨТӨЛБӨРТ ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Монгол Улсын Их Сургууль (цаашид МУИС гэнэ)-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт суралцагч элсүүлэхэд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 03 дугаар сарын 18-ны А/79 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", бусад холбогдох дүрэм, журам болон энэхүү журам (цаашид журам гэнэ)-ыг баримтална.

1.2. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт суралцагч элсүүлэх, элсэлтийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.3. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг "бүртгүүлэгч", элсэлтийн шалгалт өгч элсэх болзол хангасан бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн цахим бүртгэлийн системийг "нэгдсэн бүртгэлийн систем", элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг "элсэлтийн комисс", элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг "комиссын гишүүн" гэнэ.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИСС

2.1. Элсэлтийн комиссын даргаар Сургалт, оюутан хариуцсан дэд захирал, нарийн бичгийн даргаар Сургалтын нэгдсэн газрын дарга, гишүүдээр Элсэлтийн албаны дарга, Мэдээллийн технологийн газрын дарга, Бүрэлдэхүүн сургуулийн захирал, Тэнхимийн эрхлэгч, багш, Элсэлтийн албаны мэргэжилтэн нарыг тус тус МУИС-ийн захирлын тушаалаар томилж, Завхан, Эрдэнэт салбар сургуулийн хувьд элсэлтийн комиссыг салбар сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

2.2. Элсэлтийн комиссын дарга элсэлтийн ажлыг удирдамжаар хангаж, комиссын гишүүд элсэлтийн явцад хяналт тавих, тухайн журмаар зохицуулагдахгүй асуудлыг комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.3. Элсэлтийн алба хяналтын тоог батлуулах, элсэлтийн бүртгэл, шалгалтын хуваарь гаргах, шалгалт зохион байгуулах, дүнг системд оруулах, мэдэгдэх, бүртгүүлэгчдийн цахимаар хавсаргасан материалын бүрдлийг шалгах болон элсэлттэй

холбоотой мэдээллийг олон нийтэд түгээх (мэдээллийн хэрэгсэл, телевиз, веб хуудас) зэрэг бусад мэдээллээр ханган, зөвлөгөө өгнө. Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба элсэлт авах хөтөлбөр болон багц цаг дүйцүүлэлтийг баталгаажуулна. Бүртгэлийн алба хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийн материал шалгах, бүртгэх, сургалтын мэдээллийн систем ашиглах эрх олгох, суралцах гэрээ байгуулах, сургалтын мэдээллийн системд дүйцүүлсэн дүнг оруулах ажлыг тус тус хариуцна.

ГУРАВ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

3.1. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт бакалаврын зэрэгтэй иргэнийг элсүүлнэ (хөтөлбөрийн нэрийг хүснэгт 1, 2-д заасан болно).

3.2. Элсэлтийн бүртгэлийг дараах хуваарийн дагуу зөвхөн цахим хэлбэрээр хийнэ.
Үүнд:

- Оройн хөтөлбөрийн бүртгэл: 06 дугаар сарын 20-ноос 08 дугаар сарын 20-ний өдрийг дуустал,
- Эчнээ хөтөлбөрийн бүртгэл: 07 дугаар сарын 20-ноос, 09 дүгээр сарын 20-ний өдрийг дуустал,
- Завхан сургуулийн хувьд эчнээ хөтөлбөрийн бүртгэл: 07 дугаар сарын 20-ноос, 09 дүгээр сарын 20-ний хооронд, 02 дугаар сарын 10-наас 03 дугаар сарын 03-ны өдрийг дуустал

3.3. Элсэлт авах хөтөлбөр, элсэлтийн бүртгэл, элсэлтийн шалгалтын хуваарь зэрэг элсэлттэй холбоотой бусад мэдээллийг Элсэлтийн алба элсэлт авах бүр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, <https://burtgel.num.edu.mn> цахим хуудсанд байршуулна.

3.4. Шинээр бүртгүүлэгч нь бүртгэлийн нэгдсэн системд хувийн болон системийн шаардсан бусад мэдээлэл (цахим шуудангийн хаяг, нэвтрэх үг)-ийг зааврын дагуу оруулан баталгаажуулж, нэвтрэх эрх авна.

3.5. Нэвтрэх эрхээ авсан бүртгүүлэгч бүртгэлийн нэгдсэн систем дэх анкетыг бөглөж, дараах баримт бичгийн эх хувийн хуулбарыг цахим хэлбэрээр хавсаргана.
Үүнд:

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар (жолооны үнэмлэх, гадаад паспорт)
- Өмнө нь эзэмшсэн боловсролын диплом, түүний хавсралтын хуулбар (Гадаадад боловсрол эзэмшсэн бол албан ёсны орчуулга хийлгэн, нотариатаар батлуулсан байна)
- Цээж зураг

3.6. Бүртгүүлэгч хэдэн ч хөтөлбөрт бүртгүүлэн шалгуулж болох ба элсэлтийн шалгалтандаа тэнцсэн зөвхөн нэг хөтөлбөрт суралцах эрх авна.

3.7. Бүртгүүлэгч бүртгүүлсэн хөтөлбөрийн тоогоор бүртгэлийн хураамжийг цахимаар төлнө.



ДӨРӨВ. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ

4.1. Бүртгүүлэгч нь элсэхийг хүссэн хөтөлбөрт харгалзах элсэлтийн шалгалт өгнө.

4.2. Шалгалтын зохион байгуулалтыг элсэлтийн комисс хариуцан гүйцэтгэнэ. Шалгалтыг мэргэжлийн тэнхим үнэлж, үнэлгээг шалгалт авсан өдөрт нь багтаан Элсэлтийн албанд ирүүлнэ.

4.3. Шалгалт авах өдөр, цаг, хэлбэрийн тухай мэдээллийг шалгалт авахаас 7 хоногийн өмнө <https://burtgel.num.edu.mn> цахим хуудасны шалгалтын хуваарь цэсэнд байршуулна.

ТАВ. ЭЛСЭХ ЭРХ ОЛГОХ

5.1. Шалгалтад авбал зохих онооны 60-аас дээш хувийг авсан бүртгүүлэгчдийг оноогоор нь жагсааж, онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ. Оноо тэнцсэн тохиолдолд өмнө эзэмшсэн бакалаврын зэргийн дипломын голч дүнг харгалзана.

5.2. Бүртгүүлэгчдэд шалгалтын дүн болон хяналтын тоонд багтсан эсэхийг шалгалт дууссаны дараа бүртгэлийн нэгдсэн системээр мэдэгдэнэ.

5.3. Хяналтын тоонд багтсан элсэгч 3.5-д заасан баримт бичгийн эх хувийг бүрдүүлэн заасан хугацаанд бүрэлдэхүүн сургууль дахь Бүртгэл хариуцсан мэргэжилтэнд өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

5.4. Хяналтын тоонд багтсан элсэгч нь 5.3-д заасны дагуу бүртгүүлээгүй бол элсэн суралцах эрхээсээ татгалзсан гэж үзэж тус журмын 5.1-д заасан шаардлага биелүүлсэн дараагийн бүртгүүлэгчид эрхийг шилжүүлнэ.

ЗУРГАА. БУСАД

6.1. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.

6.2. Тухайн хөтөлбөрт элсэх бүртгүүлэгчийн тоо 15-аас бага бол элсэлт авахгүй, бүртгэлийн хураамжийг буцаан олгоно.

6.3. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн бүртгүүлэгчийг МУИС-д элсүүлэхгүй, элссэний дараа энэ зөрчил илэрвэл сургуулиас хасна.

6.4. Бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн тэнхим, саналыг үндэслэн элсэгчийн өмнө нь бакалаврын зэрэг эзэмшихдээ амжилттай судалсан ерөнхий суурь хичээлээс

36 хүртэл, мэргэжлийн бусад хичээлээс 15 хүртэл багц цагийг чөлөөт сонголтод тооцож болно.


6.5. Дүйцүүлэх хичээлийг элссэн тухайн улиралд нь сургалтын мэдээллийн системд нэг удаа тооцож оруулна.

6.6. Орой, эчнээ хөтөлбөр, хяналтын тоог бүрэлдэхүүн сургуулиудын саналыг үндэслэн жил бүр МУИС-ийн захирлын тушаалаар баталж, мөрдөнө.


6.7. Элсэлтийн бүртгэлийн хураамжийг хичээлийн жил бүрийн захирлын тушаалаар батлагдсан "Сургалтын үйлчилгээтэй холбоотой хураамжийн үнэлгээ"-нд заасны дагуу авна.

6.8. Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

х х х




МУИС-ийн бакалаврын оройн хөтөлбөрт оюутан
элсүүлэх хөтөлбөрийн жагсаалт



№	Бүрэлдэхүүн сургууль	Хөтөлбөр
1	Шинжлэх ухааны сургууль	Геологи
		Багш, гадаад хэлний боловсрол
		Түүх
2	Бизнесийн сургууль	Нягтлан бодох бүртгэл
		Санхүү, банк
		Маркетинг
		Худалдаа
		Аялал жуулчлалын менежмент
3	Хууль зүйн сургууль	Эрх зүй
4	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	Мэдээллийн технологи
5	Эрдэнэт их сургууль	Багш, гадаад хэлний боловсрол

МУИС-ийн бакалаврын эчнээ хөтөлбөрт оюутан
элсүүлэх хөтөлбөрийн жагсаалт



№	Бүрэлдэхүүн сургууль	Хөтөлбөр
1	Шинжлэх ухааны сургууль	Сэтгүүл зүй
		Улс төр судлал
		Түүх
2	Бизнесийн сургууль	Нягтлан бодох бүртгэл
		Худалдаа
3	Хууль зүйн сургууль	Эрх зүй
4	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	Цаг уур
		Хүрээлэн буй орчин судлал
		Статистик
5	Эрдэнэт их сургууль	Нягтлан бодох бүртгэл
6	Завхан сургууль	Нягтлан бодох бүртгэл
		Санхүү, банк